



ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Аудитын тайлан

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг:

Аудитын менежер:
Утас: 70562147
Цахим хаяг:

Аудитор:
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг: Чингис хот
Байршил: АЗДТГ-ын байр 315 тоот
Цахим хуудас:

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 4: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хавсралт 5: Менежментийн захидал

2015 оны 04 дугаар сарын 23

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Шилэн дансны хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Нэг. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.4, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.3 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн жилийн санхүүгийн тайланд / **ХЭТ-2015/15/СТА-ТЕЗ** / аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн үе шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аймгийн СТСХэлтэс Төсвийн тухай хуулийн 54.2-54.4 дахь заалтын дагуу Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 оны санхүүгийн тайланг нэгтгэж, бэлтгэн хуульд заасан хугацаанд ТАБ-т ирүүлсэн болно. Тайланд нийт 401 санхүүгийн тайланг нэгтгэсэн байна. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын 131 санхүүгийн тайлан
- Тусгай шилжүүлгийн төсөвт байгууллагын 112 санхүүгийн тайлан
- Халамжийн сангийн 23 санхүүгийн тайлан
- ОНХСангийн 23 санхүүгийн тайлан
- ОНӨҮГ-ын 34 санхүүгийн тайлан
- Төсөл сангийн 78 санхүүгийн тайлан
- Төрийн сангийн нэгжийн 23 санхүүгийн тайлан зэрэг болно.

Дээрх тайлангуудыг Сангийн сайдын 2006 оны 32 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Plastic 1.0” программаар бэлтгэн гаргажээ.

Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайланг гаргахдаа УСНББОУС-ын дагуу бэлтгэн гаргахыг зорьж, стандартад заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэлийн аккрузль суурийг хэрэглэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд:

- Санхүүгийн тайлангийн тодруулга нь хэлхээ холбоотой талуудын тодруулга, өр төлбөр зэрэг мэдээллийг оруулсан байна.
- Орон нутгийн төсвийн санхүүгийн нэгтгэсэн тайланг төгрөгөөр, тодруулга тайланг мянган төгрөгөөр илэрхийлсэн байна.

Аймгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 04 дүгээр сарын 01 -нээс 2015 оны 04 дүгээр сарын 20 -ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын ахлах аудитор Н.Туяа, аудитор Ү.Төгсжаргал нар гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 04 дүгээр сарын 25 -нд аймгийн удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Татварын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай болон Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд бүтэц зохион байгуулалтын хувьд өөрчлөлт ороогүй.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Аймгийн төрийн сан нь төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, аймгийн Засаг даргыг чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь үйлчлэх, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх төрийн захиргааны байгууллага юм.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд төрийн сангийн нийтлэг чиг үүргийг Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 37.1 дугаар зүйлд “ төсвийн хэрэгжилтийг зохион байгуулах, түүнд хяналт тавих, төсвийн орлого, өдөр тутмын гүйлгээг хийх, төсвийн хяналтыг зардлыг бүлэглэсэн дүнгээр хэрэгжүүлэх, төсвийн зарлагын төлбөрийн дарааллыг тогтоох, төсвийн гүйлгээг цахим сиситемээр хэрэгжүүлж хяналт тавих, төсвийн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу холбогдох дансанд бүртгэх, тайлагнах, төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 1.17 -д “ аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн энэ хуулийн 14.1.15, 14.1.16-д зааснаас бусад төсвийн” гэж заасны дагуу аймгийн Засаг дарга орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаас олгож байна.

Төрийн сантай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар аймгийн ТЕЗ-ийн 2014 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын

уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Тухайн аудитад хамрагдсан төсөвт байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой бүртгэлийн программ уялдсан байна.

Аймгийн Төрийн санд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нийт 1970357.3 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд үлдэгдлийг байгууллагаар нь авч үзвэл: Төсөл санд 763430.0 мянган төгрөгийн, төрийн санд 1064554.2 мянган төгрөгийн, төсөвт байгууллагад 29940.8 мянган төгрөгийн, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжид 11243.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд дансны 8437.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байгаагаас 88.1 хувь буюу 7433.9 сая төгрөг нь Сум хөгжүүлэх сан, ЖДБДСангаас олгосон зээлийн авлага эзэлж байна.

Төсөвт байгууллагууд 658.1 сая төгрөгийн, Төрийн сан 78.2 сая төгрөгийн, ОНӨҮГазрууд 266.8 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна. Төсөвт байгууллагын авлага орон нутгийн болон тусгай шилжүүлгийн нэмэлт дансны үлдэгдэл 182.2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэнтэй холбоотойгоор нэмэгдсэн байна.

Нийт 3974.8 сая төгрөгийн бараа материалын 3438.6 сая төгрөг буюу 86.5 хувь нь төсөвт байгууллагын, 456.5 сая төгрөг буюу 11.5 хувь нь ОНӨҮГ-ын, 79.7 сая төгрөг буюу 2 хувь нь төсөл сангийн бараа материал байна.

Нийт 104122.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн 97110.7 сая төгрөг буюу 93.3 хувь нь төсөвт байгууллагад, 6993.6 сая төгрөг буюу ОНӨҮГазарт, 17.7 сая төгрөг нь төсөл санд ногдож байна.

Нийт 758.1 сая төгрөгийн богино хугацаат өглөгийн 465.6 сая төгрөг буюу 61.4 хувь нь ОНӨҮГ-ын, 70.0 сая төгрөг буюу 9.2 хувь нь төсөвт байгууллагын, 40.2 сая төгрөг буюу 5.3 хувь нь төсөл сангийн өглөг байна.

2040.2 сая төгрөгийн урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэл нь Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр 2004 оноос 9 аймагт Нийтийн ахуй үйлчилгээний ажлыг сайжруулах дэмжих зорилгоор олгогдсон төслийн зээлийн өглөг байна.

Аудитаар ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн материаллаг түвшинг нийт зардлын 1 хувь буюу 1047.1 сая төгрөгөөр тогтоов. /ТАБ-СТА-А-4/

Тав. Дотоод хяналт:

Бид аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Аудитад хамрагдсан төсөвт байгууллагууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл,

санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар болон Төрийн сан тайлангийн нэгтгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Аймгийн Төрийн сангийн дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Үүнд: Аудитын явцад зарим уурын зуухны эзэд, захирал нар аймгийн Засаг даргын 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 220 тоот захирамжид заасан хугацааг хэтрүүлэн халаалт өгснөөс, төсвийн 13 байгууллага халаалтын төлбөрийг 5 хоногоор буюу нийт 12291,1 мянган төгрөгөөр илүү төлсөн, Хэрлэн сумын Төрийн сан, Багийн Засаг дарга нар нь компьютер техник хэрэгсэл худалдан авахаар хувь хүний харилцах дансанд 2166.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгийг аваагүй атлаа нягтлан бодогч нь хуурамч баримт бүрдүүлэн хий орлогоор бүртгэсэн, ГХБХБГ-ын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитаар ашиглалтанд хүлээлгэн өгөөгүй конторын барилгын халаалт болон цэвэр, бохир усны төлбөрт 10,5 сая төгрөгийг “Оч манлай” ХХК, “Хэнтий Ус” ХК-тай хуурамч гэрээ байгуулж тус байгууллагын дансаар дамжуулан гаргаж авч 5,0 сая төгрөгийг төсвийн гадуур зарцуулсан, 5,5 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зэрэг зөрчил илэрсэн нь төрийн сангаас төсөвт байгууллагуудын ажил гүйлгээнд тавих хяналт хангалтгүй байгааг харуулж байна.

Зургаа. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу аймгийн төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Аймгийн ИТХ-ын 2013 оны 12 дугаар сарын 04-ний хуралдаанаар Хэнтий аймгийн 2014 оны төсвийн орлого, зарлагын төлөвлөгөө 56607,4 сая төгрөгөөр батлагдсанаас, Төсвийн тухай хуулийн 34.2.1-д заасны дагуу төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 6 дугаар сарын 16-нд хийсэн тодотголоор 2716,8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, 12 дугаар сарын 22-нд хийсэн тодотголоор 310,7 сая төгрөгөөр бууруулан, 59013,4 сая төгрөгт хүргэжээ. Үүн дээр сумын орлогоос санхүүжих 1995.1 сая төгрөгийн зардлыг нэмж тооцвол аймгийн хэмжээнд төсөвт зардлыг 61008,5 сая төгрөгөөр баталсан байна. Төсвийн орлогыг авч үзвэл:

Хэнтий аймгийн 2014 оны орлогын төлөвлөгөөний биелэлт

/сая.төгрөгөөр/				
№	Орлогын төрөл	Төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү
1	Татварын орлого	7,639.50	7,425.60	(213.90)
2	Татварын буцаан олголт	(505.30)	(505.30)	-
3	Татварын бус орлого	780.70	924.50	143.80
4	Хөрөнгө худалдсаны орлого	180.00	123.10	(56.90)
5	ТУСЛАМЖИЙН ОРЛОГО:	52,913.60	50,287.70	(2,625.90)
5.1	ОНХСангийн орлогын шилжүүлэг	10,461.50	8,445.60	(2,015.90)
5.2	Санхүүгийн дэмжлэг	9,610.60	9,610.60	-

5.3	Тусгай зориулалтын шилжүүлэг	30,172.10	30,168.50	(3.60)
5.4	Хандивын орлого	156.00	383.50	227.50
5.5	ТЗШ-ийн өөрийн орлого	116.20	170.20	54.00
5.6	Урьд оны үлдэгдлээс	2,397.20	1,509.30	(887.90)
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО		61,008.50	58,255.60	(2,752.90)

Нийт орлого 2752.9 сая төгрөгөөр тасарсан нь орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 2015.9 сая төгрөгөөр дутуу ирсэнтэй холбоотой байна.

Татварын буцаан олголтыг хасч тооцвол татварын орлого 6920,3 сая төгрөгөөр биелж, төлөвлөгөөнөөс 213,9 сая төгрөгөөр тасарсан нь рашаан ус ашигласны төлбөр 317,8 сая төгрөгөөр, газрын дуудлага худалдааны орлого 68,3 сая төгрөгөөр, авто тээврийн хэрэгслийн татварын орлого 64,1 сая төгрөгөөр, ангилагдаагүй бусад орлого 49,6 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсантай холбоотой байна.

Төсвийн гүйцэтгэлээр нийт зардлыг авч үзвэл 61008,5 сая төгрөг зарцуулахаас 58255,6 сая төгрөгийг зарцуулж, 2752,9 сая төгрөгөөр буюу 4,5 хувиар хэмнэж ажиллажээ.

Нийгмийн халамжийн зардал 388,8 сая төгрөг, үүний дотор халамжийн тэтгэвэр 240,9 сая төгрөг, амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тусламж 139,4 сая төгрөгөөр, жирэмсэн, хоол тэжээлийн тусламж, дэмжлэг 70,1 сая төгрөгөөр, амаржсан эхийн тэтгэмж 46,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна. Харин ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт 137,1 сая төгрөгөөр хэтэрсэн байна.

Мөн төсөвт байгууллагын цалин хөлсний зардал 173,5 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний тогтмол зардал 120,4 сая төгрөгөөр, бусад зардал 315,1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 1701,2 сая төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Орон нутгийн төсвийн 58255,6 сая төгрөгийн нийт зарлагын гүйцэтгэлийн бүтцийг авч үзвэл: Нийт зарлагын 10,8 хувь буюу 6311,1 сая төгрөгийг нийгмийн халамжийн зардал, 46,7 хувь буюу 27201,3 сая төгрөгийг цалин хөлс, шимтгэлийн зардал, 5,4 хувь буюу 3176,7 сая төгрөгийг бусад бараа үйлчилгээний тогтмол зардал, 12,8 хувь буюу 7487,1 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардал, 20,1 хувь буюу 11719,6 сая төгрөгийг хөрөнгийн зардал эзлэж байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудад 18266,6 сая төгрөгийн төсөв батлагдаж, 17436,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, гүйцэтгэлээр 17164,5 сая төгрөгийг зарцуулж, 321,2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Мөн орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын нэмэлт дансны үлдэгдэл 182,2 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 30288,3 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 30081,0 сая төгрөгийг зарцуулж 208,2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Долоо. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгө, авлага, өглөг, үндсэн хөрөнгө, бараа материал зөрүүтэй тусгагдсан байх, баримтгүй болон баримтын бүрдэлгүй

орлого, зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгасан байх, хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй байх, төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэн тохируулаагүй байх, зардлын зүйл ангиудыг батлагдсанаас зөрүүтэй зарцуулсан байх зэрэг аудитын 23 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан сорил гүйцэтгэв.

Санхүүгийн аудитаар өр авлагыг бүртгэл, тайланд бүрэн тусгаагүй, тооцооны үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, анхан шатны үндсэн баримтгүй буюу бүрдэл дутуу баримтаар хөрөнгө мөнгө зарлагадах, ажиллагсдаас суутгасан НД-ын шимтгэл, ХХОАТ-ыг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй, ажиллагсдаас дутуу суутгасан цалингийн урьдчилгааг авлагаар бүртгээгүй, “Төсвийн байгууллагын мөнгөн кассын журам”-ыг зөрчиж үндсэн хөрөнгө, бараа материалын үнийг бэлнээр олгох, бараа материал үндсэн хөрөнгийн тооллогыг хийгээгүй, эсвэл чанаргүй хийх, ажиллагсдын цалингийн ангилал зэрэглэлийг буруу тогтоож илүү цалин олгох, төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулах, санхүүгийн ажил гүйлгээг бүртгэл тайланд зөрүүтэй илэрхийлэх, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй зэрэг зөрчил дутагдал нийтлэг илэрлээ.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулах, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх зэрэг сөрөг үр дагаварт хүрч болзошгүй байна.

Найм.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад сумдын төрийн сангийн нэгтгэсэн тайлан дахь төсөвт байгууллагуудын харилцах дансны ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн, нарийвчилсан сорилын аргаар шалгалаа.

Аудитад бүх сум, тосгоны Төрийн сангийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, орон нутгийн төсөвт байгууллагуудаас АЗДТГазар, аймгийн ИТХурал, Засаг даргын нөөц сан, ангилагдаагүй зардал, орон сууцны сан, замын сан, зэргийг хамруулан санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, сумдын ЗДТГазарт албан томилолтын зардал, ИТХурлын цалингийн зардал, Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, ЕБСургуулийн үдийн цайны зардал, Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал, Соёлын төвийн цалингийн зардал, Эмийн эргэлтийн сангийн зарим гүйлгээ ихтэй дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын горим, нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Аймгийн Аудитын газар ҮАГ-ын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2014 оны “ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудитыг хийж дуусгасан, мөн “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д нийцлийн аудитыг хийж байгаа тул энэхүү аудитад баримтыг хамруулаагүй болно.

“ Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн аудитаар дараах зөрчлүүд гарсан байна. Үүнд:

- 2014 оны хөрөнгө оруулалт, их засварын 22 төсөл, арга хэмжээ нь зураг, төсөвгүйгээр батлагдсан ба аудитын явцад зураг төсөвгүй 7, зураггүй боловч төсөвтэй 9 ажил, үлдсэн 9 ажлын зураг төсвийг мэргэшсэн төсөвчид хийж гүйцэтгэсэн байна.
- 2014 онд хэрэгжих хийт 25 төсөл арга хэмжээний 2 нь буюу Дэлгэрхаан, Жаргалтхаан сумын төвлөрсөн дулаан хангамж байгуулах ажлыг гүйцэтгэгч тал

концессийн зарчмаар түлхүүр гардуулах нөхцөлтэйгээр хүлээлгэн өгөх бөгөөд 22 буюу 88 хувь нь ажлын зураг төсөв хийлгэх гэрээ байгуулаагүй, 24 буюу 96 хувь нь улсын экспертизээр баталгаажаагүй төдийгүй зураг төсвийг хүлээн авсан тухай баримтгүй байгаа нь ажил эхлэхээс өмнө зураг төсөв батлагдсныг нотлож чадахгүй байна.

- Аймгийн ҮХААГ захиалагчийн хяналтыг сайн тавьж 23 худгийг бүрэн ашиглалтанд оруулсан бол зураг төсөв болон захиалагчийн хяналтын зардалд 72,7 сая төгрөгийг суутган авсан боловч аймгийн ГХБХБГ нь захиалагчийн хяналтыг хангалттай хэрэгжүүлээгүйгээс төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд хэрэгжихгүй байх, хувийн хэргийг дутуу бүрдүүлэх, алданги тооцоогүй зэрэг зөрчлүүд гарсан байна.
- Захиалагч гүйцэтгэгчийн хооронд байгуулж буй гэрээнд талуудын хүлээх үүрэг хариуцлага, гэрээний тусгай нөхцөлд Монгол улсын Иргэний хуулийн дагуу алданги тооцох тухай заалтыг орхигдуулснаар төсөл, арга хэмжээ гэрээний хугацаанд дуусахгүй байх, гүйцэтгэгч талд хариуцлагаас зайлсхийх нөхцлийг бүрдүүлж, үүний улмаас нийт 13,4 сая төгрөгийн алданги тооцох боломжгүй болгожээ.
- Нийт төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 52 хувийг аймаг, сумдын Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авахаар тусгахдаа шаардагдах хөрөнгийг дутуу төлөвлөж байгаа болон автомашины техникийн үзүүлэлт, ашиглалтын ямар шаардлага хангахыг нэгдсэн байдлаар тодорхойлоогүйгээс сум бүр батлагдсан төсөвт багтаан, өөр өөр шаардлага тавьж, зарим тохиолдолд элэгдэл өндөртэй, 7-14 жил Монгол улсад ашиглагдсан, ашиглалтын зардал ихтэй автомашин худалдан авч төсвийн хөрөнгийн үр ашгийг бууруулж байна.
- Хөрөнгө оруулалтаас автомашины худалдан авалт зохион байгуулагдсан 8 сумын төрийн байгууллага автотээврийн хэрэгслийг үндсэн хөрөнгөнд бүртгэсэн боловч зарим сумд тээврийн хэрэгслийн эзэмшигчийн бүртгэлийн өөрчлөлтийг хийгээгүйгээс худалдан авсан автомашинууд нь гадны дугаартай байгаа нь худалдан авах ажиллагаа бүрэн дуусаагүй, хөрөнгө эзэмших эрх шилжээгүй зэрэг зөрчил дутагдлууд илэрсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайлангийн аудитаар 21 төрийн сан, 28 байгууллагын, нийт 49 санхүүгийн тайланд аудит хийсэн байна. Хүснэгтийг хавсралт № 1-ээр үзүүлэв.

Үүнээс аймгийн Аудитын газар 16 төсөвт байгууллагын, сумын ТЕЗ-ийн 21 төрийн сангийн тайлан, ТШЗ-ийн 4 санхүүгийн тайлан, ОНӨҮГын 5 тайланд аудит хийсний дээр аудитын 2 компанитай гурвалсан гэрээ байгуулан ТШЗ-ийн 10 тайлан, ОНӨҮГ-ын 9 санхүүгийн тайланд аудитыг гүйцэтгүүлээ.

Ес.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад **хураангуйлан тэмдэглэв**. Аудитын явцад материаллаг хэмжээний 1277922,2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүү тайлангийн бараа материалын эхний болон эцсийн үлдэгдлийг бараа материалын дэлгэрэнгүй тайлангийн үлдэгдэлтэй тулгахад:
 1. Баянхутаг сумын ЭМТөвийн бараа материалын үлдэгдэл 344.3 мянган төгрөгөөр, Мөрөн сумын Соёлын төв бусад хангамжийн материалын эхний үлдэгдэл нь дэлгэрэнгүй тайлангаасаа 60.0 мянган төгрөгөөр, Хурх тосгоны ЗАА-ны бичиг хэргийн **материалын тайлангийн оны эхний болон эцсийн**

- үлдэгдэл няравын гаргасан дэлгэрэнгүй тайлангаас 12.4 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй,
2. АЗДТГазар хөрөнгийн орлогод аймгийн ангилагдаагүй зардлын данснаас Алтаргана наадмын санхүүжилтээр бэлтгэсэн 9500,0 мянган төгрөгийн календарь, 6300,0 мянган төгрөгийн наадмын сидиг бараа **материалын дансанд бүртгээгүй,**
 3. АЗДТГазар бичиг хэргийн материалын дансанд 2725,5 мянган төгрөгийн **материал зарцуулагдсан боловч журналд зарлагадаагүй, дансанд үлдэгдлээр** илэрхийлэгдсэн,
 4. ХБУлаан тосгоны ЕБС хүнсний **материалд** хөлдөөгч, угаагч, махны машин зэрэг 649,1 мянган төгрөгийн **хөрөнгийг бүртгэсэн,**
 5. АЗДТГазар үндсэн хөрөнгийн **элэгдлийн зардлыг** 3142,7 мянган төгрөгөөр, Баянмөнх сумын ЭМТөв үндсэн хөрөнгийн **элэгдлийг** 246.0 мянган төгрөгөөр, Мөрөн сумын ЭМТөв машин тоног төхөөрөмжийн **хуримтлагдсан элэгдлийг** 688,6 мянган төгрөг, тавилга эд хогшилын **хуримтлагдсан элэгдлийг** 717,5 мянган төгрөгөөр, бүгд 1406,1 мянган төгрөгөөр **дутуу тооцсон,**
 6. Баянмөнх сумын ЗДТГазар тайлант онд данснаас хассан үлдэгдэл өртөгтэй **үндсэн хөрөнгийн дансны бичилтийг буруу бичиж тайлант оны үр дүн болон үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдлийг** 21312.5 мянган төгрөгөөр **зөрүүтэй илэрхийлсэн,** мөнгөн гүйлгээний тайланд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 6931.3 мянган төгрөгийн **үндсэн хөрөнгийг зардал хооронд сольж бүртгэсэн,**
 7. АЗДТГазар **санхүүгийн тайланд авлага, өглөгийн дүн** 679,8 мянган төгрөгөөр **дутуу илэрхийлэгдсэн,**
 8. Биндэр сумын ЗДТГазар **төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого** 1.9 сая төгрөг, **зарлага** 26.0 сая төгрөгөөр, АЗДТГазар төсвийн гүйцэтгэлийн тайланд **орлогыг** 380067,7 мянган төгрөгөөр, **зарлагыг** 287769,4 мянган төгрөгөөр, Өлзийт тосгоны ЗААлба 11392.5 мянган төгрөгөөр, ХБУлаан тосгоны ТЕЗ-ийн **төсвийн гүйцэтгэлийн зарлагын тайланг** 157274,5 мянган төгрөгөөр тус тус **зөрүүтэй илэрхийлж, нэмэлт дансны орлого, зарлагын гүйлгээг** төсвийн гүйцэтгэлийн тайланд **тохируулах бичилт хийж цэвэрлээгүй ,**
 9. Баянхутаг сумын ЗДТГазар бараа материалын тодруулгын тайлангийн **хандиваар болон шилжүүлэн авсан дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн бараа үйлчилгээний орлогын дүнгээс** 437,0 мянган төгрөгөөр, Баянмөнх сумын ЗДТГазар **үнэ төлбөргүй авсан бараа материалыг орлого** 900.0 мянган төгрөгийн **дансны бичилт буруу хийж орлого үр дүнгийн тайланд орлогыг,** Баянмөнх сумын ЕБС **үнэ төлбөргүй авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого** 40447.0 мянган төгрөгийг **дансны бичилт буруу хийж орлого үр дүнгийн тайланд орлогыг** тус тус **зөрүүтэй илэрхийлсэн,**
 10. Баянхутаг сумын ЭМТөв **мөнгөн гүйлгээний тайлан, санхүүгийн үр дүнгийн тайланд орлого, зарлагыг** 2068.8 мянган төгрөгөөр **илүү тайлагнасан,** Бэрх тосгоны ЕБС **мөнгөн гүйлгээний тайлангийн үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүнг** 1415,1 мянган төгрөгөөр **дутуу илэрхийлсэн,**
 11. Баян-Овоо сумын ЗДТГазрын санхүүгийн тайлангийн **мөнгөн гүйлгээний тайлан** 378.2 мянган төгрөгөөр **зөрүүтэй, төсвийн гүйцэтгэлийн орлого** 2939,4 мянган төгрөгөөр **зөрүүтэй, бүрэн тохируулаагүй буюу илүү илэрхийлсэн,**

12. ГХХБАлба нь аймгийн Монгол банкинд 2015 оны **түрээсийн төлбөр болох 2531,1 мянган төгрөгийг урьдчилан төлсөн боловч УТЗ-аар бүртгээгүй зардалд хааж, дансны харьцаа буруу хийсэн** нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.1-д “Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь НББОУС-д нийцсэн байх” гэснийг зөрчсөн байна.
13. Хурх тосгоны ЗААлба тайлант онд **дуусаагүй барилга дансанд орлого авсан 20.0 сая төгрөгийн халуун усны барилгыг гарзаар бүртгэсэн, төсвийн гүйцэтгэлийн тайланд нэмэлт дансны 45662,9 мянган төгрөгийг орлого, зарлагыг тохируулаагүй, зөрүүтэй зэрэг 1103966,2 мянган төгрөгийн алдаа илэрсэн байна.**
- **Шийдвэрлэсэн нь: Дээрхи бүртгэл тайлагналтай холбоотой 1103966,2 мянган төгрөгийн алдаануудыг санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.**
1. **Албан томилолтын зардлыг** Баянхутаг сумын ЗДТГазар ажилтнуудад 58,0 мянган төгрөгөөр, Баянмөнх ЗДТГазар 178.5 мянган төгрөгөөр, Жаргалтхаан сумын ЗДТГ 58,0 мянган төгрөгөөр **тогтоосон хэмжээг хэтрүүлэн олгосон, Дадал сумын ЗДТГазар томилолтын хуудсанд тамга дарагдаагүй, хоног нэмж зассан зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу 96,0 мянган төгрөг, тогтоосон норм хэмжээг хэтрүүлэн олгосон 35,5 мянган төгрөг, Байгаль орчны алба 106.5 мянган төгрөгийн томилолтыг, ХБУлаан тосгоны ЗААлба 60,0 мянган төгрөгийн байрны үнийг томилолтын зардалтай давхардуулан илүү олгосон** нь Сангийн Сайдын 2011 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын хэмжээг батлах тухай” хэмжээг мөрдөж ажиллаагүй,
2. Жаргалтхаан сумын ЗДТГ-ын албан томилолтын зардлыг шалгахад **томилолтын хоног нэмж зассан зэрэг анхан шатны баримтын бүрдэл дутуу 145,0 мянган төгрөг, 132,0 мянган төгрөгийн албан томилолтын тооцоог анхан шатны баримтын дагуу авлагаар бүртгээгүй шууд зардалд бичсэн зэрэг зөрчил илэрсэн,**
3. ГХБХБАлба нь Оч манлай ХХК-тай гэрээ хийж 9633,0 мянган төгрөгийн халаалтын төлбөр төлсөн, Хэнтий Ус ХК-тай гэрээ байгуулж 882,0 мянган төгрөгийн усны төлбөр төлсөн зэрэг 10515,0 мянган төгрөгийг **хуурамч баримт бүрдүүлэн гүйлгээ хийж байгууллагад хохирол учруулж төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан** нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1.4-д “Хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих” гэснийг зөрчсөн тул 5517,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 4997,7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна.
4. Байгаль орчны алба 97.5 мянган төгрөгийн **шатахууны зардлыг анхан шатны баримтгүй зарцуулсан, 248.0 мянган төгрөгийг шинэ жилийн баярын арга хэмжээнд зарцуулж, ЗГ-ын 147-р тогтоолын заалтыг зөрчсөн, 222.6 мянган төгрөгийн шатахууны зардлыг илүү тооцож олгосон,**
5. Хэрлэн сумын ЗДТГазар **хуурамч баримт бүрдүүлэн хувь хүний харилцах дансанд 2166.0 мянган төгрөгийг шилжүүлсэн** байгаа нь НББ-ийн тухай хуулийн 7.6, 18.1 дэхь заалтуудыг зөрчсөн,

6. Хэрлэн сумын **ЗДТГазар төсвийн хөрөнгөөр Чингис хотын шинэ жилийн арга хэмжээнд** 3478,0 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, Төсвийн тухай хуулийн 16.5.5, 6.4.1 дэхь заалтуудыг зөрчсөн,
7. Хэрлэн сумын 4-р сургууль аймгийн Засаг даргын 2014 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 220 дугаар захирамжийг үндэслэн халаалтын төлбөрийг тооцож олгоогүй, 4 дүгээр сард халаалтын төлбөрийг 5 хоногоор буюу 3182.7 мянган төгрөгөөр, АИТХурал 63,2 мянган төгрөгийн халаалтын төлбөрийг тус тус илүү шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 дахь заалтыг зөрчсөн зэрэг 16272.9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

• **Шийдвэрлэсэн нь: Дээрхи зөрчлүүдийг арилгах 16272.9 мянган төгрөгийн 16 төлбөрийн акт тогтоосон.**

1. Ангилалдаагүй зардлын Алтаргана наадмын санхүүжилтээр худалдан авсан 9426,0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийн үлдэгдлийг болон Засаг даргын нөөц сангийн хөрөнгөнөөс ЗДТГазрын ажиллагсадад 4500.0 мянган төгрөгийн бэлтгэлийн хувцас, чийрэгжүүлэлтийн танхимд 5429.0 мянган төгрөгийн чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж, шинэ жилийн арга хэмжээнд 500.0 мянган төгрөгийн шинэ жилийн гацуур мод худалдан авсан боловч бүртгэл тайланд тусгаж тайлагнаагүй, Байгаль орчны алба " Орон нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийн замаар ядуурлыг бууруулах" төслөөс ирсэн 17240,1 мянган төгрөгийн хөрөнгийг орлогод бүртгэж аваагүй,
2. АЗДТГазар үндсэн хөрөнгийг данснаас шилжүүлэх шийдвэр гараагүй байхад Хэрлэн 1 цэгт 19918,3 мянган төгрөгийн, Хэрлэн, Биндэр, Мөрөн, Баян-Овоо сум, Өлзийт тосгонд 18068,5 мянган төгрөгийн, нийт 37986,8 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн боловч санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгасан нь санхүүгийн тайлангийн оршин байх, үнэн зөв байх, эрх үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй,
3. Хэрлэн сумын **ЗДТГазар Багийн ЗДаргын төсвөөс** 3000,0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн,
4. АЗДТГазар өмнөх оны 1577,4 мянган төгрөгийн авлагыг, 2014 оны 2495,8 мянган төгрөгийн аудитын төлбөрийн актын өглөгийг барагдуулах арга хэмжээ аваагүй, Байгаль орчны алба 11,3 сая төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй,
5. Цэнхэрмандал сумын Цэцэрлэг хүүхдийн хоолны зардлыг тогтоосон нормоос 1211.3 мянган төгрөгөөр, Бор-Өндөр сумын "Бүжинхэн" Цэцэрлэг хүүхдийн хоолны зардлыг тогтоосон нормоос 3006.7 мянган төгрөгөөр хэтрүүлсэн,
6. ХБУлаан тосгоны Цэцэрлэгийн хүүхдийн хоолны материалын зарцуулалтыг шалгахад үлдэгдэл санхүүгийн тайлангаас зөрүүтэй, хүүхэд өдрийн нормыг мөрдөөгүй 9-12 сард 590,7 мянган төгрөгийн материалыг тогтоосон хэмжээнээс илүү зарцуулсан, 1099,0 мянган төгрөгийн махыг анхан шатны баримтгүйгээр бөөн дүнгээр шууд зарлагдсан, анхан шатны баримт болон тайланг үнэн зөв хийдэггүй, материалын зарцуулалтад тавих хяналт хангалтгүй, материалын үлдэгдэл санхүүгийн тайлангаас зөрүүтэй,

7. ХБУлаан тосгоны ЕБСургуулийн 2366,4 мянган төгрөгийн үдийн цайны зарцуулалтыг шалгахад **хүүхэд өдрийн тоонд хяналт тавиагүй, материалыг шууд зарлагдсан,**
8. ХБУлаан тосгоны ЕБСургуулийн **эд хариуцагчийн тайлан хагас дутуу, тайлангийн үлдэгдэл санхүүгийн тайлантай тохирохгүй,** дотуур байрны **хүүхдийн хоолны зардлыг 9-12 сард 1620,0 мянган төгрөгөөр дутуу буюу тогтоосон хэмжээнээс бага зарцуулсан,**
9. Баян-Адрага сумын Байгаль хамгаалах сангаас зарцуулсан шатахууны зарцуулалтыг үзэхэд 641 литр буюу 1095,9 мянган төгрөгийн **шатахууныг шаардах хуудасгүй, хийх ажлын зориулалтыг баримтаар бүрдүүлээгүй, тодорхойгүйгээр Засаг дарга, ТГ-ын холбогдох ажилтнууд зарцуулсан байгаа нь Байгаль хамгаалах, нөхөн сэргээх сангийн журамтай нийцээгүй, зориулалт бусаар зарцуулсан,**
10. Аймгийн ИТХурал **төлбөр хураамжийн зардлыг илүү төлөвлөж,** 34800,0 мянган төгрөгийн **хөрөнгө худалдан авсан** зөрчилтэй байна. Үүнд: автомашин 25,0 сая төгрөг, хэлмэгдлийн хөшөө 2,5 сая төгрөг, 7,3 сая төгрөгийн компьютер тоног төхөөрөмж худалдан авч санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын зүйл ангийг зөрүүлэн бүртгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 “ Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтад нийцээгүй байна,
11. Хэрлэн сумын ЗДТГазар **ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгийн техник хяналтын зардлын 2 хувь болох 10779,0 мянган төгрөгийг нэмэлт дансанд төвлөрүүлж байгууллагын урсгал үйл ажиллагаанд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1, 16.5.5 заалтуудыг зөрчсөн зэрэг 157682,9 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.**
 - **Шийдвэрлэсэн нь: Дээрхи илэрсэн 157682,9 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.**

1. Хурх тосгоны ЭМТөвийн **бичиг хэргийн материалын тайлан 9,4 мянган төгрөгөөр, эм боох материалын тайлан 1,5 мянган төгрөгөөр, хүнсний материалын тайлан 1,4 мянган төгрөгөөр эхний болон эцсийн үлдэгдэл, АИТХурлын бараа материалын тайлангийн үлдэгдэл нийт 335,5 мянган төгрөгөөр, Баян-Адрага сумын ЭМТөвийн тусгай зориулалттай материал 137,0 мянган төгрөгөөр, хүнсний материал 4.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,**
2. Биндэр СДОй анги мод үржүүлгийн талбайд буй 513 909 ширхэг **тарьц суулгацыг орлогоор бүртгээгүй,**
3. Байгаль орчны албаны эд хариуцагч 4945.0 мянган төгрөгийн **материалын тайланд орлого авч, зарлага гаргахдаа анхан шатны баримтгүй тайлан гаргасан,**
4. Норовлин сумын ЗДТГ-ын албан томилолтын зардлыг шалгахад **томилолтын хуудас зассан, анхан шатны баримтын бүрдэл дутуу 265,5 мянган төгрөг, томилолтын зардлаас зориулалт бусаар 41,0 мянган төгрөгийн ном, гарын авлагын үнэ төлсөн, Өлзийт тосгоны ЗАА албан хаагчдад дотоод албан томилолтыг тогтоосон норм хэмжээнээс 72.0 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон** зэрэг нийт 306,5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

5. Бор-Өндөр сумын ЗДТГазар 129.0 мянган төгрөгөөр **томилолтын зардлыг илүү тооцож олгосон, томилолтоор ажилласан газраар гарын үсэг зурж баталгаажаагүй байхад** 251.5 мянган төгрөгийн **томилолт олгосон** байна.
6. Хүүхдийн Ясли **тушаал шийдвэр гараагүй байхад хүүхдийн хоолны зардлаас** хүүхдийн баяраар 242,0 мянган төгрөгийн **бэлэг олгосон** байгаа нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг зөрчсөн байна.
7. Дадал сумын ЕБС-ийн **дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг** 1,5 сая төгрөгөөр **хэтрүүлэн зарцуулсан,**
8. Өмнөдэлгэр сумын ЕБС-ийн үдийн цайны зарцуулалтыг анхан шатны баримт, нягтлан бодох бүртгэлтэй тулган шалгахад 1757,4 мянган төгрөгийн **үдийн цайны зардлыг анхан шатны баримтын дагуу бүртгээгүй, дараа сард гүйлгэн бүртгэсэн** байна,
9. АИТХурал **тушаал шийдвэргүй, төсөв тооцоогүйгээр зориулалт тодорхойгүй** 719,5 мянган төгрөгийг **хоолны үнэ төлөхөд,** 2000,0 мянган төгрөгийг **хүнсний материал,** 9078,0 мянган төгрөгийг **бэлэг дурсгалын зүйл худалдан авахад зарцуулсан,** ЗГ-ын 147 дугаар тогтоолын **төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулах зарчимд нийцээгүй,**
10. АИТХурал хуралд суудалтай **намд олгох дэмжлэгийг нэмэгдүүлэн тодотгож,** 116,0 сая төгрөгийг **гадаад албан томилолтын зардалд зарцуулсан** нь Төсвийн тухай хууль болон ЗГ-ын 147 дугаар тогтоолын **арвилан хэмнэлттэй зарцуулах зарчимд нийцээгүй,**
11. Хэрлэн сумын ЗДТГазар сумын **мэргэжилтэнүүдийн хувийн харилцах дансанд** 6916,1 мянган төгрөгийг **шилжүүлсэн байгаа нь Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмын 6.2,6.3 дахь заалтыг зөрчсөн,**
12. Хэрлэн сумын ЗДТГазар **ажилчдад олгосон урамшуулалын дүнгээс** 820,1 мянган төгрөгийн **НДШ суутган тооцоогүй** байгаа нь НД тухай хуулийн 16 дугаар зүйл заалтыг зөрчсөн,
13. Баянхутаг сумын Цэцэрлэгийн **цалингийн зардал санхүү үр дүнгийн тайланд** 66690.9 мянган төгрөгөөр, **мөнгөн гүйлгээний тайланд** 66616.9 мянган төгрөгөөр буюу 74.0 мянган төгрөгөөр **илүү илэрхийлэгдсэн зөрчил илэрсэн,**
14. Өлзийт тосгоны ЭМТөв **бараа материалын** 14467.5 мянган төгрөгийн **үлдэгдлийг тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй, эд хариуцагч нь сар бүр бараа материалын тайлан гаргаж нягтлан бодогчид хянуулдаггүй, эм боох материалын дэлгэрэнгүй бүртгэлийн үлдэгдэл эд хариуцагчийн тайлангаас** 520.5 мянган төгрөгөөр **зөрүүтэй,**
15. Өмнөдэлгэр сумын ЭМТөв 14 нэр төрлийн **хөрөнгөд** 2574,3 мянган төгрөгийн **элэгдлийг тооцоогүй,**
 - **Шийдвэрлэсэн нь: Дээрхи илэрсэн 174654,2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх зөвлөмж хүргүүлсэн.**

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Жилийн эцэст хөрөнгийн тооллого тооцоог хийгээгүй санхүүгийн тайлан гаргасан нь НББ-ийн тухай хууль болон ТБОНӨ-ийн тухай хуулийн заалтыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Хурх тосгоны ЗААлба эд хөрөнгийн тооллогыг явуулах комисс томилсон Захирагчийн захирамж гарсан боловч, тооллогын комисс 11.8 сая төгрөгийн бараа материал, 444.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг тоолоогүй **хуурамч тооллогын бүртгэл бүрдүүлсэн,**
 - Баян-Адрага ЭМТөвийн 18335,5 мянган төгрөгийн **бараа материалын үлдэгдлийг тоолж баталгаажуулаагүй, үндсэн хөрөнгийн тооллогыг чанартай хийгээгүй, тооцоог хийгээгүй,**
 - АИТХурал жилийн эцэст **үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого тооцоо хийгээгүй,**
 - Хурх ЭМТөв няравын гаргасан **үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланг ирүүлээгүй тул, үндсэн хөрөнгийн тулгалт хийх боломжгүй байна.** Мөн тооллогын комисс нь хөрөнгийн тооллогыг хийхдээ чанартай явуулаагүй,
 - Хурх тосгоны ЕБСургууль жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө 35.6 сая төгрөгийн **бараа материал, 244.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдлийг тоолоогүй,**
 - Өлзийт тосгоны ЭМТөвийн бараа материалын үлдэгдэл 14467.5 мянган төгрөгийн **үлдэгдлийг тооллого хийх тушаал шийдвэр гаргаагүй** байна.
2. Хурх тосгоны ЗААлба, Өлзийт тосгоны ЗААлба **авлага, өглөгийн үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй.**

- **Шийдвэрлэсэн нь: Дээрхи материаллаг бус алдаа зөрчлийг дахин давтахгүй байх зөвлөмж өгсөн.**

Арав. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад өглөг, авлагыг барагдуулаагүй, жилийн эцэст хөрөнгийн тооллого хийгээгүй, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн материаллаг бус алдаа илэрсэн нь цаг хугацааны шалтгаанаар залруулах боломжгүй байна.

Арван нэг. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

2014 онд Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор "Алтаргана-2014" наадам Дадал суманд зохион байгуулагдсан байна.Үүнд: Аймгийн Засаг даргын 2014 оны 06 дугаар сарын 25-ны А/386 тоот захирамжаар Алтаргана наадмыг зохион байгуулах зардалд 350,0 сая төгрөгийг ангилагдаагүй зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэжээ. Үүнд: Засгийн газрын нөөц сангаас 100,0 сая төгрөг, ССАЖЯамнаас 89,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн, үлдэх 160,4 сая төгрөгийн зардлыг аймгийн төсвөөс зарцуулсан байна.

Наадмыг зохион байгуулах салбар хороодын зардлын төсвийг гарган, батлаж, үндсэн баримтын дагуу зардлыг санхүүжүүлж ажилласан байна.

Засгийн газрын нөөц сангаас ирүүлсэн 100,0 сая төгрөгийн зарцуулалтыг авч үзвэл хүлээн авалтын зардалд 10,2 сая төгрөг, зочид угтан авахад 10,6 сая төгрөг, онцгой байдал үер усны зардалд 5,0 сая төгрөг, эрч хүчний хангалтад 19,9 сая төгрөг, хэв журам сахиулахад 12,0 сая төгрөг, мэргэжлийн хяналтын ажиллагаанд 2,3 сая төгрөг, сумдын гэр барих шатахууны зардалд 4,6 сая төгрөг зарцуулжээ.

"Иргэний санхүүгийн боловсрол" ТББ-тай гэрээ байгуулан ажиллаж "Алтаргана -2014" 1000 ш календар гаргахад 9,5 сая төгрөг," Алтаргана" нэвтрүүлэг 9,0 сая төгрөг, "Дэлхийн

буриад” нэвтрүүлэг 9,0 сая төгрөг, 350 ш сиди бичлэг гаргахад 7,0 сая төгрөгийг тус тус шилжүүлжээ.

ССАЖЯамнаас санхүүжүүлсэн 89,7 сая төгрөгийг урлагийн ажлын хэсэгт 11,7 сая төгрөг, бөхийн барилдааны зардалд 7,3 сая төгрөг, буриад сурын харваанд 14,3 сая төгрөг, хөтөч орчуулагчийн зардалд 9,3 сая төгрөг, мандат олгох зардалд 3,2 сая төгрөгийг тус тусын салбар хороодод олгон зарцуулжээ.

Алтаргана наадмын санхүүжилтээр бэлтгэсэн 9500,0 мянган төгрөгийн календарь, 6300,0 мянган төгрөгийн наадмын сидиг бараа материалын дансанд бүртгээгүй байсныг АЗДТГазрын бүртгэл тайланд тусгуулсан ба мөн 9426,0 мянган төгрөгийн болон Засаг даргын нөөц сангаас бэлтгэсэн 10429,0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийн үлдэгдлийг данс бүртгэлд орлогоор бүртгэж аваагүй зөрчлийг бүртгэл тайланд тусгуулах албан шаардлагыг СТСХэлтэст хүргүүллээ.

Арван хоёр. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын явцад цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан орон нутгийн төсөвт байгууллагуудын санхүүгийн баримтуудыг гүйцээж мөшгин шалгаж амжаагүй тул завсарын аудитаар авч үзэхээр боллоо.

Арван гурав.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар **нийт 1502253,6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн** ба үүнээс **1103966,2 мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 157682,9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг** дахин давтан гаргахгүй байх 17 **албан шаардлага хүргүүлж, 16272,9 мянган төгрөгийн төлбөрийн 16 акт тогтоож, залруулагдаагүй 58654,2 мянган төгрөгийн алдаа болон 165677,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өгч,** холбогдох албан тушаалтанд **хариуцлага тооцуулах 9 албан шаардлагыг хүргүүллээ.**

Аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн тайланд нэгтгэгддэг Төрийн сан, байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн нэгтгэлийг хавсралт № 02 – т үзүүлэв.

Арван дөрөв. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Аймгийн ТЕЗ-ийн 2013 оны санхүүгийн тайланд аймгийн Аудитын газраас хийсэн аудитаар санхүүгийн тайланг төсвийн тухай хуульд заасан хугацааны дотор аудитад хамруулж байх 5 зөвлөмж өгсөн бөгөөд төрийн захиргааны албан хаагчдыг үндэслэлгүй халж, төсвөөс шүүхийн шийдвэрээр цалинг нөхөн олгодог зөрчлийг таслан зогсоох зөвлөмжийг хэрэгжүүлж, сангуудын өглөг авлагын үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах зөвлөмжийг хагас хэрэгжүүлж, төрийн албан хаагчдын өмнөөс урьдчилан төлсөн орон сууцны үнийн авлагыг яаралтай барагдуулж, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, сум тосгоны Эмийн эргэлтийн санг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулж, татварын албанд татвар төлөгчөөр бүртгүүлэх, ОНӨҮГ-уудын санхүүгийн тайлан гаргалт, НББ-ийн хөтлөлт хангалтгүй байгаа тул санхүүгийн программ хангамжтай болгох асуудлыг шийдвэрлэх зэрэг зөрчлийг арилгах зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

2013 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн 134 зөвлөмж бүрэн хэрэгжсэн ба хязгаарлалттай санал дүгнэлт авч, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоодын хяналтыг хангалтгүй хэрэгжүүлсэн 3 албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналыг холбогдох дээд газарт хүргүүлснээс хариуцлага тооцуулах 2 санал хэрэгжсэн байна. Аймгийн ЗДТГазар сүүлийн 3 жил, аймгийн ИТХурал 2 жил дараалан хязгаарлалттай санал дүгнэлт авсан боловч санхүүгийн тайлангийн аудитаар энэ дүгнэлт давтагдсан байна.

Арван тав. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

2015 онд Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн судалгааг ТЭЗ-ийн хүрээнд 1, ТТЗ-ийн хүрээнд 22, ТШЗ-ийн хүрээнд 215, ТБОНӨ хуулийн этгээдийн 9 байгууллага буюу нийт 247 байгууллагад байршуулбал зохих мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудсанд хэрхэн байршуулсаныг хянан үзэж гаргалаа.

Судалгаагаар 247 байгууллагаас нэгдсэн цахим хуудсанд 15.8 хувь буюу 38 байгууллага мэдээллийг байршуулаагүй, “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай” журмын 4.1, 7.2-ын заалтыг зөрчсөн байна. Үүнд: Дэлгэрхаан, Жаргалтхаан, Цэнхэрмандал, Баянмөнх, Баян-Овоо, Баянмөнх, Баянхутаг, Норовлин сумын ТЭЗ болон Гурван баян, Өлзийт, ХБУ-н тосгоны Захирагч, ЗХ-ний 232-р анги, Улсын Нөөцийн Хэнтий салбар, Онон голын сав газар, Баянхутаг сумын ЗДТГ, БЗД, Баянмөнх сумын ИТХ, ЗДТГ, БЗД, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Дархан сумын БЗД, ХБУ тосгоны Цэцэрлэг, ЭМТ, Цэнхэрмандал сумын ИТХ, Баян-Овоо сумын ИТХ, Гурван баян тосгоны ЗАА, ЕБС, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төв, Норовлин сумын БЗД, Тахилгат тосгоны ЗАА, Аймгийн Номын сан, Хэрлэн сумын “Ач манал”, “Оюуны шим”, “Хэрлэн дом” өрхийн эмнэлгийн зэрэг төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч нар шилэн дансны хууль, журмыг хэрэгжүүлээгүй байна.

Нэгдсэн цахим хуудсанд 2 байгууллага байршуулбал зохих мэдээллээс 5 мэдээллийг оруулсан бол, 21 байгууллага 3-4 мэдээллийг оруулж, 185 байгууллага буюу 75 хувь нь 1-2 мэдээллийг оруулжээ.

Мэдээллийг шивсэн бүх байгууллагууд батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийг нийтлэг оруулж, 9 байгууллага 5 саяаас дээш үнэ бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилт, хэмжээ, нийлүүлэгчийн хаягийг оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд 247 байгууллагаас 15 орчим хувь нь байршуулсан байна.

“Хэнтий-Ус” ХХК мэдээллийг байршуулахад бааз үүсэхгүй, шивэхэд алдаа гарч, холбогдогдох хүмүүстэй ярьсан ч мэдээллийг байршуулж чадаагүй байгаа тайлбаруудыг өгсөн болно.

Мэдээллээ нэгдсэн цахимд огт байршуулаагүй, шилэн дансны хуулийг зөрчсөн байгууллагын дарга нарт шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах тухай албан бичиг хүргүүлэхээр ажиллаж байна.

Арван зургаа. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Санал дүгнэлтийн үндэслэл

ТЭЗ-ийн 2014 оны санхүүгийн тайлангийн материаллаг байдлын түвшинг нийт зардлын 1 хувь буюу **1047.1 сая төгрөгөөр тогтоосон** бөгөөд аудитын явцад хийсэн сорилын үр дүнд санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдтэй зөрчилдсөн нийт 1502,2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 1104,0 сая төгрөгийн алдаа зөрчлийг санхүүгийн тайланд залруулж, 16,3 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, **залруулагдаагүй 381,9 сая төгрөгийн**

алдаа зөрчил илэрсэн ч материаллаг гэж үзээгүй тул аймгийн ТЕЗ-ийн 2014 оны санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгөх үндэслэл боллоо.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 14 хуудас, гэрчилгээ 1 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ЭНХТҮВШИН

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.НАРАНЦЭЦЭГ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР

Н.ТУЯА

АУДИТОР

Ү.ТӨГСЖАРГАЛ

Огноо: 2015.04,24